

ТӨВ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

1944 онд аймгийн яаманд төлөвлөгөө-тоо бүртгэлийн байгууллагын суурь тавигдаж 2 хүний орон тоотой хэлтэс байгуулагджээ. Төв аймгийн хөдөлмөрчдийн хурлын гүйцэтгэх захиргааны 1960 оны 7дугаар сарын 29-ны өдрийн 116 тоот захирамжаар Төв аймагт Статистикийн товчоо анх байгуулагдаж даргаар нь Өлзийн Хаянхярваа, тоо бүртгэгчээр Рэвүзийн Дамдинсүрэн, Буянгийн Лувсан-Ёндон, Дэндэвийн Цэрэнхүү, Сандагийн Дашням нар томилогдон ажиллах болсноор тус албаны тулгын чулууг тавьж цаашдын хөгжил дэвшлийн замын эхлэл байлаа. 1960-2000 онуудад аймгийн статистикийн товчоо, хэлтсийн даргаар ажиллаж байсан Ө.Хаянхярваа, Ц.Цэрэнхүү, Л.Нацагдорж, Д.Аюуш, Л.Ган-Өлзий, П.Цэрэн, сумын АДХГЗ-ны орлогч дарга, Засаг даргын орлогчоор ажиллаж байсан Д.Дамдинпүрэв, Н.Мижид, Ч.Чүлтэм, Д.Алтангэрэл, Д.Доржсүрэн, Ц.Жадамбаа, Т.Баярхүү, Ж.Сольбат, статистикийн товчоо, хэлтсийн мэргэжилтэн С.Амарбат, Ц.Бямбаа, С.Дуламсүрэн, Д.Найдан, Нарангэрэл, С.Ундрахбаяр зэрэг бүртгэл-статистикийн үйл ажиллагааг аймаг, сумын төвшинд эрхлэн явуулахдаа мэргэжлийн өндөр ур чадвар, онцгой идэвх зүтгэл, үр бүтээл гарган манлайлан ажилласан тэргүүний олон хүмүүсийг онцлон тэмдэглэж байна. Бүртгэл мэдээллийн ажилд орчин үеийн тооцоолох техник хэрэгсэл нэвтрүүлэх чиглэлээр улс, орон нутгийн статистикийн албад ямагт анхдагч болж ирлээ. Улсад анхны тооцоолон бодох техникийн төв Статистикийн Төв Газарт 1974 онд байгуулагдан ажилласан бол тус аймагт статистикийн албанд 1984 онд мэдээлэл боловсруулж, бэлтгэж, шууд дамжуулах зориулалттай **МЕРА-100** хэрэглэгчийн цэгийн микро машиныг суурилуулж, ашиглалтанд оруулсан нь тухайн үедээ аймаг-улсын хооронд бий болсон анхны сүлжээ болж, богино хугацаанд мэдээлэл солилцох бололцоог бүрдүүлсэн чанарын үйл явц байлаа. 1991 оноос анхны **"МОНЕЛ"** персональ компьютерыг аймгийн статистикийн албанд ашигласнаар мэдээлэл дамжуулах, электрон хүснэгт ашиглан тоо мэдээллийг боловсруулан, нэгтгэж үр дүнгийн хүснэгтүүд гаргаж авах чиглэлд хийсэн чанарын эрс өөрчлөлтийн үе эхэлж бүртгэл тооцооны ажилтнууд калькулятор, үзэг, харандаа, баллуурнаас хараат бус болох эхлэл болсон үйл явц байлаа. 2000 оноос эхлэн сумын төвшинд статистикийн үйл ажиллагаа явуулдаг сумын Засаг даргын орлогч нар зөвхөн графикт мэдээ, тайланг нэгтгэн гаргаж дээд

шатны байгууллагад дамжуулах төдийгөй улмаар мэдээлэлдээ боловсруулалт хийж сумын хэрэглэгч нарт статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг болсон. Албан ёсны статистикийн мэдээ, тайлангаар сумын нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга гаргаж хэрэглэгч нарт үйлчлэх, тооллого судалгааны дүнгээр динамик хөтлөлтөөр Зуунмод, Батсүмбэр, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Заамар, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Сүмбэр, Өндөрширээт зэрэг сумд бусдаас илүү хэрэгжүүлжээ. Сумын ДНБ-ий тооцоог Зуунмод, Лүн, Заамар, Батсүмбэр, Баяндэлгэр, Мөнгөнморьт зэрэг сумд тооцож үйл ажиллагаандаа хэрэглэдэг болов.